

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймаг дахь Засаг даргын төсөл хөтөлбөрийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ОРА-2023/93/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Эрдэнэт хот

2023 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Буян-Ундрах
Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn

Ахлах аудитор: В.Жавзмаа
Утас: 70357955 Цахим хаяг: javzmaav@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2023.08.25 № 100

танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
С.БАТЖАРГАЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Засаг даргын төсөл хөтөлбөрийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Засаг даргын төсөл хөтөлбөрийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Өмнөх оны авлагыг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар бүрэн барагдуулсан байна.

Төсөл, хөтөлбөрийн нийт зардлаас 1.8 хувь нь анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаагүй баримтаар баталгаажуулж, тайлагнасан байна.

Аудитын гол асуудал

Орхон аймгийн Засаг даргын төсөл хөтөлбөрийн орлого, зардлыг 12,558,580.8 мянган төгрөгөөр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталж, гүйцэтгэлээр 12,559,559.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, баталсан хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийн зардалд 11,264,513.8 мянган төгрөгийг зарцуулж, 1,295,045.7 мянган төгрөг орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар хүрэх үр дүн, хэрэгжилтийг нэгтгэж үнэлнэ.

Тухай аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй төрийн аудитын албан хаагчид аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРМАНДАХ



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>15,310,000</u>	-
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
33	АВЛАГА	15,310,000	-
335	Бусад авлага	15,310,000	-
3351	Байгууллагаас авах авлага	15,310,000	-
34	УРЬДЧИЛГАА	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	-	-
36	НӨӨЦИЙН БАРАА	-	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	-	-
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>15,310,000</u>	-
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>15,310,000</u>	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15,310,000	-
413	Өглөг	15,310,000	-
41330	Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	15,310,000	-
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	-	-
51	Засгийн газрын хувь оролцоо	-	-
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>15,310,000</u>	-

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	10,596,435,900.00	12,559,559,500.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,573,500.00	979,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,573,500.00	979,500.00
120009	Бусад орлого	7,573,500.00	979,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,588,862,400.00	12,558,580,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	10,588,862,400.00	12,558,580,000.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	10,588,862,400.00	12,558,580,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	10,596,435,900.00	12,559,559,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,596,435,900.00	12,559,559,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,332,923,168.41	10,081,761,675.02
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,332,923,168.41	10,081,761,675.02

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,332,923,168.41	10,081,761,675.02
212	ТАТААС	1,030,857,569.91	1,182,752,156.18
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	1,030,857,569.91	1,182,752,156.18
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	1,030,857,569.91	1,182,752,156.18
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,232,655,161.68	1,295,045,668.80
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,232,655,161.68	1,295,045,668.80
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,232,655,161.68	1,295,045,668.80
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-	-

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	10,690,018,464.00	13,124,144,426.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,573,500.00	979,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,573,500.00	979,500.00
120002	Хүүгийн орлого	7,573,500.00	
120009	Бусад орлого		979,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,682,444,964.00	13,123,164,926.80
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	10,588,862,400.00	12,558,580,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	10,588,862,400.00	12,558,580,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	93,582,564.00	564,584,926.80
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	93,582,564.00	564,584,926.80
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	10,690,018,464.00	13,124,144,426.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,690,018,464.00	13,124,144,426.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,348,233,168.41	10,081,761,675.02
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,348,233,168.41	10,081,761,675.02
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,348,233,168.41	10,081,761,675.02
212	ТАТААС	1,030,857,569.91	1,182,752,156.18
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	1,030,857,569.91	1,182,752,156.18
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	1,030,857,569.91	1,182,752,156.18
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,310,927,725.68	1,859,630,595.60
2132	Бусад урсгал шилжүүлэг	93,582,564.00	564,584,926.80
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	93,582,564.00	564,584,926.80
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,217,345,161.68	1,295,045,668.80
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,217,345,161.68	1,295,045,668.80

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл				0.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
Тайлант үеийн үр дүн				0.00
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
Тайлант үеийн үр дүн			0.00	0.00
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитын явцад залруулж тайлагнах алдаа гараагүй болно.

Аудитаар нийт 196,104.9 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 13,224.8 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 182,880.1 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн.

5.1 Төлбөрийн акт

Байгалийн ухаан инженерчлэлийн Эрдэнэт сургалтын төвийн төсөл хэрэгжүүлэх зардлыг зарцуулаагүй төсвийг төсөвт төвлөрүүлээгүй, Засаг даргын А/927 дугаар захирамжаар сурагчдад программ бичих, хөгжүүлэх сургалтын цахим мэдээлэл бэлтгэн түгээх ажлыг гүйцэтгээгүйд төлбөрийн акт тогтоосон болно.

5.2 Албан шаардлага

Бараа, ажил үйлчилгээ худалдан авах, гүйцэтгүүлэхдээ цахим төлбөрийн баримтыг бүртгэсэн хэдий ч гэрээ хэлцлийг дүгнээгүй, эрх бүхий албан тушаалтан гэрээг баталгаажуулаагүй, жолоочийн тооцооны хуудсыг бүрэн хөтлөөгүй, анхан шатны баримт болох бараа материалын зарлагын баримтад тоо хэмжээ, үнийн дүнг бичээгүй, бөөн дүнгээр бичсэн, төсөл хөтөлбөрийн үр дүнг үнэлээгүйд албан шаардлага хүргүүлсэн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг Орхон аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын тайланд тусгана.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгуул-лагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөг/				Зөвлөмж		
							Үүнээс						
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруу-лаагүй		Тоо	Дүн	
Засаг даргын төсөл хөтөлбөр													
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгуул-лагын нэр	Нийт зөрчил		/мянган төгрөг/										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Засаг даргын төсөл хөтөлбөр	4	196,104.9	2	13,224.8	1	182,880.1							
Дүн	4	196,104.9	2	13,224.8	1	182,880.1							

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	-	-	-	-	-	-	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			